МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2015.05.07 № 2/110

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
П.МАРГАД-ЭРДЭНЭ НАРТ

Зөрчил арилгуулах тухай

"Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус компани нь 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тохируулгыг хийгээгүй, тайлант хугацааны татварын зорилгоор байгуулсан элэгдлийн зардал буруу илэрхийлэгдсэн зэрэг материаллаг алдаатай гаргаж ирүүлсэн байна.

Уг санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг Үндэсний аудитын газарт хянах явцад компанийн хүсэлтээр дээрх алдааг залруулах боломжийг олгосны дүнд 2014 оны 4 дүгээр сарын 10-нд 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг дахин залруулсан дүнгээр гаргаж ирүүлсэн. Тайланд хийсэн залруулгыг нягтлах үүднээс "Улаанбаатар аудит корпораци" ХХК-ний аудиторууд 5 хоног аудит хийж, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын мэргэжилтнүүд дахин хяналт хийгээд залруулсан дүнгээр санхүүгийн тайланг хүлээн авч болох талаар зөвшилцөлд хүрсний дүнд аудитын дүгнэлтийг эцэслэн гаргах нөхцөл бүрдсэн байна.

Санхүүгийн тайлангийн дээр дурьдсан материаллаг алдаа, түүнээс үүдсэн нөхцөл байдал нь "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ний санхүүгийн албаны удирдлагуудын мэдлэг, мэргэжил, ажлын хариуцлага, зохион байгуулалттай холбоотой бөгөөд энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтыг тус тус зөрчихөд хүргэсэн.

Нөгөө талаас дээрх үүссэн нөхцөл байдал нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг зохих стандартын дагуу боловсруулж дагаж мөрдөөгүй, санхүүгийн програмын боловсруулалтыг технологийн түвшинд бүрэн хийж хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Иймд "Төрийн аудитын тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..." заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

Дээрх нөхцөл байдлын улмаас Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг зохих шаардлагын түвшинд хүргэж боловсронгуй болгон өөрчлөх,

компанийн нягтлан бодох бүртгэлийг түүний дагуу явуулах, санхүүгийн албаны удирдлагуудын мэдлэг, ажлын хариуцлага, зохион байгуулалтын байдалд зохих дүгнэлт хийж, шаардлагатай арга хэмжээ авахыг "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал П.Маргад-Эрдэнэ нарт даалгасугай.

Энэхүү албан шаардлагын биелэлтийг 2015 оны 6 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН

АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ОЙДОВ

УХА0122